

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНЫ ТӨЛӨВШИЛ

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЭЭЗүйн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн ахлах дэслэгч Л.Бат-Очир

Сүүлийн үед гэмт хэргийн гаралт, шинж байдал, өөрчлөгдөж байгаа төдийгүй шинэ төрлийн гэмт хэрэг гарах явдал ихсэх хандлагтай байна. Энэ нь зах зээлийн нийгмийн өөрчлөлт, хөгжилтэй салшгүй холбоотой юм.

Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх түүний үр нөлөөг дээшлүүлэх, гаралтыг багасгах, шалтгаан нөхцлийг арилгахын үндэс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй бодитой үр дүнтэй, зохион байгуулах явдал юм.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах гол арга нь судалгаа, шинжилгээ юм. Үнэн бодитой бүртгэл судалгаа түүнд хийсэн шинжилгээ дүгнэлтгүйгээр гэмт хэрэг зөрчил, түүний шалтгаан нөхцөлийг илрүүлж бууруулах, бүх талын иж бүрэн системтэй арга хэмжээг зохион байгуулах боломжгүй тул гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тал бүрээс нь нарийвчлан судлах, бүртгэл, мэдээллийн систем арга хэлбэрийг сайжруулах, олон нийтийг хамарсан нийтлэг буюу нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө чанарыг дээшлүүлэх ёстой.

Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг илрүүлэх түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн хуулийн байгууллагын чиг үүрэг мэтээр ойлгох бус иргэд аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын хуулиар хүлээлгэсэн үүрэг, хамтын ажиллагаа гэж ойлгох учиртай юм.¹ Зарим аж ахуйн нэгж байгууллага дээр үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулахгүй хуулиар хүлээсэн үүргээ умартан зөвхөн ашиг хонжоо олох байдлаар хандаж байгаагийн улмаас нэг аж ахуйн нэгж байгууллага дээр гарсан гэмт хэргийн тоо ихсэх, дахин давтагдах тохиолдол цөөнгүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд² зааснаар хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч тухайн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохион байгуулах тухай мэдэгдэл хүргүүлдэг ч нэр төдий хандах, үл тоомсорлох, мэдэглийн хүрээнд ажил зохион байгуулахгүй байх, энэ талаар хариу мэдээлэхгүй байх зэрэг дутагдал байсаар байна.

Энэ нь хариуцлагын хүлээлгэхгүй байх, тухайн аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, албан хаагчдын эрх зүйн ухамсар соёл дутмаг байгаатай холбоотой юм. Ер нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг чухал хэсэг бол иргэдийн хууль эрх зүйн соёл ухамсар, дутмаг, тэдний ухамсар соёлыг дээшлүүлэх ажилийг зохион байгуулах эрчимжүүлэх ажил мөн.

Иргэдийн хууль эрх зүйн ухамсар соёлыг дээшлүүлэх ажлыг зөвхөн сургалт, ярилцлагаар хязгаарлахгүйгээр бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиуд аж ахуйн нэгж байгууллагуудад тусгай төлөвлөгөөний дагуу тодорхой үе шаттай сургалт зохион байгуулах нь зүйтэй юм. Энэ ажилд хууль зүйн сургалт

¹. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 он.

². Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль. 2002 он. 22, 190 дугаар зүйл.

явуулдаг төрийн болон төрийн бус их дээд сургуулиудын оюутнууд, багш нарыг татан оролцуулж болох юм. Иргэдийн ухамсар соёл дээшилснээр хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн бодлогыг хүндэтгэн сахих, иргэний үүргээ биелүүлэх нөхцөл боломж бүрдэнэ.

Хуулийн хэм хэмжээг чанд сахин биелүүлэх, бие биенээ хүндэтгэх, улмаар өөрийгөө хүндлэх явдлыг иргэн бүрийн дотоод үзэл бодол, болгож хэвшүүлснээр хуулиар хүлээсэн үүргээ чин шудрагаар биелүүлэх нөхцөл бүрдэх ба энэ талаар В.И.Ленин³ “ олон түмэн бүхнийг мэдэж бүх юмны зөв бурууг ялган шүүж, юм бүрт ухамсартай хандах болсон тэр цагт манай төр засаг, хууль ёс хүчтэй байх юм” гэж хэлсэн байдаг. Иргэдийн ухамсар соёлыг дээшлүүлэх гол арга нь итгүүлэх ухамсарлуулах явдал бөгөөд тэгэхдээ албадах аргыг үгүйсгэж болохгүй ба дээр аргуудыг зөв хослуулан хэрэглэх нь эрх зүйн ухамсар соёл, хүмүүжилд чухал ач холбогдолтой. Ардчилсан төр бол ухамсартай дэг журамтай нарийн зохион байгуулалттай хуулийн хэм хэмжээнд захирагддаг байх явдалд тулгуурладаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэг гүйцэтгэдэг ч сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр гэмт хэрэг зөрчлийн талаар олон төрлийн нэвтрүүлэг гарч байгаа ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулгагүй харин иргэд олон нийтийн сонирхолд тулгуурласан реалити шоуны хэв маягтай нэвтрүүлгүүд олширч байна. Тухайлбал “Гэмт хэргийн халуун мөрөөр”, “Деррик”, “Шөнийн толь”, “Хавтаст хэрэг”, “ зэрэг нэвтрүүлгүүдийг дурдаж болно. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд⁴ “Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн тухай мэдээлэл хийхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл, хор холбогдлыг олон түмэнд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно”, хэрэв хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг гаргасан бол хориглоно⁵ гэж заажээ. Гэтэл дээрх нэвтрүүлгүүдээр гэмт хэрэг үйлдэж байгаа арга хэлбэрийг нарийвчлан харуулж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дээрх заалтыг зөрчөөд зогсохгүй өсвөр насны хүүхэд залуучуудын зан төлөв, ёс суртахуунд сөргөөр нөлөөлж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын гол зорилго нь түүнийг үйлдсэнийх нь дараа бус үйлдэгдэхээс нь өмнө гаргахгүй байх талаар урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талын ажлийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохион байгуулах явдал юм. Иргэдийн эрх зүйн ухамсар, соёл хичнээн өндөр байх тусам төрийн хуулийг хүндэтгэн сахиж иргэний үүргээ шудрагаар биелүүлэх нөхцөл бүрдэнэ. Хуулийн хэм хэмжээг хүндэтгэн сахих явдлыг хүн бүрийн үзэл бодол, итгэл үнэмшил болгож хэвшүүлснээр хууль биелүүлэх явдлыг бүх нийтийн үйл хэрэг болгон өрнүүлэх ёстой. Насанд хүрээгүй иргэдийг зөв хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд эцэг эх, багш нарын үүрэг хариуцлага ёс суртахуун, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх асуудал чухал юм. Хүүхдийн хүмүүжил, зан төлөвд сөргөөр нөлөөлөх аливаа гаж буруу үзэгдэл, нөлөөллийн талаар сургамжилж өвөг дээсдээс уламжилж ирсэн өтгөс буурлаа хүндлэх, буруу үйлийг тэвчих, эх орон байгал

³.Социалист хууль ёс сэтгүүл .1974 он.№ 1

⁴.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.1997 он.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

⁵. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.1997 он.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

дэлхийгээ хайрлах, хүнлэг ариун сэтгэлтэй, эрдэм номыг бишрэн шүтдэг зэрэг эрхэм нандин өв уламжлал зан заншлыг ухамсарлуулан таниулж байх нь хүүхдийн хүмүүжилд эерэгээр нөлөөлж, сайн хүн болж төлөвших нь дамжиггүй юм. Сүүлийн үед архи согтууруулах ундаа ихээр хэрэглэж байгаа нь олон төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл болж байсан. Ялангуяа танхайрах, дээрэмдэх, хулгайлах, хүний биед гэмтэл учруулах, хүнийг санаатай алах гэмт хэргүүдийг ихэвчлэн согтууруулах ундаа хэрэглэж үйлдэх боллоо.

Архидан согтууралтын хор хохирлыг тайлбарлан таниулах, зөв зохистой хэрэглэх талаар сургалт зохион байгуулах явдлыг эрчимжүүлэх, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах явдал учир дутагдалтай байгаа бөгөөд элдэв учир шалтгаангүйгээр, баяр ёслолын үеэр далимдуулан хэрэглэхийг хязгаарлах зайлшгүй шаардлагтай.

Нийгмийн харилцаа улам хөгжиж боловсронгуй болох тусам хууль, ёс суртахууны хэм хэмжээний харилцан нөлөөлөл нэмэгдэж хуулийн хэм хэмжээ иргэдийн зан суртахууны хэвшил болсоор байна. Нөгөө талаар төрийн зүгээс хууль тогтоомжийг ард иргэдэд сурталчлах ажил дутмаг, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон нийтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулдаг ажиллагаа дутмаг, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны ил тод бус байдал иргэдийн ухамсар соёлд сөргөөр нөлөөлж байгаа нь хэсэгчилсэн судалгаанаас харагдаж байна.

Ийм учраас эрх зүйн ухамсар соёл нь түүний мэдлэгээс ихээхэн шалтгаалах ба эрх зүйн ухамсар соёлыг дээшлүүлэхэд хүн амын бүтцийг нарийвчлан судалж тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлийг тодорхой үе шаттай хэрэгжүүлэх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой юм.